



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/526

Булган сум

Аймгийн Музей, Хөгжимт жүжгийн театр,
Төв номын сангийн 2023 оны эхний хагас жилийн
гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үнэлгээ хийсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргатай Соёл урлагийн газрын даргын 2023 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар харьяа байгууллага болох Аймгийн музей, Хөгжимт жүжгийн театр, Төв номын сангийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Урамшууллыг батлагдсан төсөвтөө багтаан гаргахыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.


3.2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг заалт нэг бүрээр нь хяналтад авч ажиллахыг Соёл урлагийн газрын дарга (Г.Алдармөнх)-д, биелэлтийг бүтэн жилээр тооцож тайлагнахыг Хөгжимт жүжгийн театрын дарга (Ж.Халиунаа), Музейн дарга (Т.Бэхтөр), Төв номын сангийн дарга (Т.Мөнгөнтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дугаар сарын 03 ны өдрийн А/526 дугаар
захирамжийн хавсралт



Аймгийн Музей, Хөгжимт жүжгийн театр, Төв номын сангийн 2023 оны
эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	Байгууллагын нэр	Үнэлгээ хувиар	Тайлбар
1	2	3	4
1	Хөгжимт жүжгийн театр	85.5	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
2	Музей	70.2	-
3	Төв номын сан	85.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох